

ЗӨВЛӨМЖ

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч та бүхэн “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам”-ын зорилго, зохицуулах харилцаа, заалтыг хэрхэн ойлгох, үйл ажиллагаандаа хэрхэн мөрдөж ажиллах талаар дэлгэрүүлэн тайлбарласан энэхүү зөвлөмжтэй сайтар танилцсанаар Өргөн нэвтрүүлгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахад дөхөм болно гэж үзэж байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний нь Монгол Улсын Их Хурлын 2019 зах зээлд шударгаар өрсөлдөх оны 12 дугаар сарын 12-ны өдрийн нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл хуралдаанаар батлагдаж 2020 оны үүсэхээс сэргийлэх журам” нь 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин Харилцаа холбооны зохицуулах төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Өргөн хорооны 2021 оны 12 дугаар сарын нэвтрүүлгийн тухай хууль батлагдан 17-ны өдрийн 73 тоот тогтоолын гарснаар Монгол Улсад өргөн хавсралтаар батлагдаж, захиргааны нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрхзүйн хэм хэмжээний актын улсын нэгдсэн үндэс бүрдэж, өргөн нэвтрүүлгийн бүртгэлд 2021 оны 12 дугаар сарын талаар бодлого, зохицуулалтын арга 31-ний өдөр бүртгэгдсэн болно. хэмжээг хэрэгжүүлэх боломж бүрдсэн юм.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдан гарсанаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн эзэмшлийг ил тод болгох, мэдээлэх, эзэмшлийн мэдээлэлд үндэслэн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх, зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөх, нарийвчилсан зохицуулалт хийх, эдгээр харилцааг зохицуулсан журам батлах зэрэг эрх зүйн үндэслэл нь тавигдаж байгаа юм

Агуулга

- I. Журмын зорилго
- II. Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, бусад хууль тогтоомж
- III. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц
- IV. Хэн мөрдөх, хэрхэн хяналт тавих
- V. Хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байдлыг хэрхэн хангах тухай
- VI. Компанийн засаглал гэж юу вэ, яагаад компанийн засаглал чухал вэ
- VII. Бизнесийн тогтвортой байдал, санхүүгийн хараат бус байдал
- VIII. Мэдээллийн нээлттэй, ил тод байдал
- IX. Хэт төвлөрлөөс урьдчилан сэргийлэх, шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх

**“ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛД
ШУДАРГААР ӨРСӨЛДӨХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ, ХЭТ ТӨВЛӨРӨЛ ҮҮСЭХЭЭС
СЭРГИЙЛЭХ ЖУРАМ”-ЫН ТАЙЛБАР, ЗӨВЛӨМЖ**

I. ЖУРМЫН ЗОРИЛГО:

1. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийг олон нийтэд ил тод мэдээлэх, өргөн нэвтрүүлгийн салбарт хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байдлыг хангах, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх замаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой билээ.

**II. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ, БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖ:**

2. Монгол Улсын Үндсэн хуулиар улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхээр тунхаглан зарласан.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн нь төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг баталгаатай эдэлнэ” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасан байна.

4. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд дотоодын болон нийгмийн аюулгүй байдлыг хангах үндэс гэдэгт хүний эрх, эрх чөлөөг хангах, үндэсний эв нэгдлийг сахин дээдлэх, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжих, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хараат бус бие даасан байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн эзэмшил, харьяаллыг ил тод байлгах, үйл ажиллагааны бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байдлыг бий болгох, мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах чиглэлийг баримтлахаар тусгажээ.

5. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Их хурлаар соёрхон батлагдаж, 2020 оны 7 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийг олон нийтэд ил тод мэдээлэх, өргөн нэвтрүүлгийн салбарт хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байдлыг хангах, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх үйл ажиллагааг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4-р бүлэгт заасан салбарын онцлог зохицуулалтын хүрээнд тусгаж, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд бүрэн нийцүүлсэн билээ.

6. Энэхүү журмаар зохицуулсан харилцаа нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаанд баримтлах бодлого, зохицуулалтын дараах зарчмыг хангах бололцоог бүрдүүлнэ гэж үзэж байна.

- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 5.1.1: хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 5.1.4: улс төр, шашин, нийгэм, эдийн засгийн **олон ургалч үзэл бодлыг** хүндэтгэх;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 5.1.5: төр, шашны байгууллага, улс төрийн намаас **хараат бус, бие даасан** байх;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 5.1.6: **хариуцлагатай, мэргэшсэн** сэтгүүл зүйг хөгжүүлж, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөх;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 5.1.7: олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн, тэнцвэртэй, бодит мэдээ, **мэдээлэл олж авах иргэний эрхийг** хүндэтгэх;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 5.1.9: өргөн нэвтрүүлгийг эзэмшлийн **хэт төвлөрлөөс хамгаалах**, зах зээлийн өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлж, өргөн нэвтрүүлгийн салбарын хөгжлийг дэмжин хөгжүүлэх.

III. МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ:

7. Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тоот тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын бүх заалтыг НҮБ-ын гишүүн улсуудад дагаж мөрдөхийг уриалсан байдаг. Энэхүү тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.” гэж заасан.

8. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 19 дүгээр зүйлийн 19.2-т “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.” гэж заасан. НҮБ-аас өөрийн гишүүн улсуудад өгсөн удирдамжийн дагуу улс орнууд өөрийн дотоод хууль тогтоомжийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байдлыг хангах, хариуцлагатай мэргэшсэн үйл ажиллагааг дэмжих, олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн, тэнцвэртэй, бодит мэдээ, мэдээлэл олж авах иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангах зохицуулалтыг тусгайлан оруулж өгөхийг зөвлөж ирсэн.

IV. ХЭН МӨРДӨХ, ХЭРХЭН ХЯНАЛТ ТАВИХ:

9. Энэхүү журмыг өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй дараах үйлчилгээ эрхлэгч дагаж мөрдөнө:

- Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгч;
- Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч;
- Төлбөртэй телевизийн үйлчилгээ эрхлэгч;
- Радиогийн үйлчилгээ эрхлэгч;
- Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч;
- Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч.

10. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь энэхүү журмыг дагаж мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавина.

11. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэхүү журмыг мөрдөж ажиллах үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бөгөөд үйлчилгээ эрхлэгчдэд журмын хэрэгжилтийг хангах зөвлөмж, шаардлагыг хүргүүлж ажиллана.

12. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгохоор зохицуулсан байх тул энэхүү журамд Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон компанийн эрх зүйн холбогдох бусад хууль тогтоомжид заасан зохицуулалт, нэр томъёог нийцүүлэн хэрэглэхийг зорьсон.

V. ХАРААТ БУС, НЭЭЛТТЭЙ, ЁС ЗҮЙТЭЙ БАЙДЛЫГ ХЭРХЭН ХАНГАХ ТУХАЙ:

13. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхэд тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний талаар баримтлах бодлого, зохицуулалтаас гадна тусгай зөвшөөрөл олгогч байгууллага, тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгч, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой, харилцан хамааралтай этгээдийн оролцоо, үйл ажиллагаа онцгой үүрэгтэй байдаг. Иймээс оролцогч бүх талууд тухайн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхийг чармайн эрмэлзэх нь зүйтэй.

14. Тусгай зөвшөөрөл олгох байгууллагаас гаргах аливаа шалгуур, хэрэгжүүлэх зохицуулалтын арга хэмжээ нь хуулийн дагуу байх, зүй ёсны байх, зайлшгүй бөгөөд тохирсон байх зэрэг шаардлагыг хангасан байх учиртай байдаг бол эдгээр шалгуур, арга хэмжээг хэрхэн дүгнэсэн талаарх мэдээлэл ил тод нээлттэй болсноор хараат бус, ёс зүйтэй байдал хангагдах, шударга өрсөлдөх нөхцөл бүрдэх юм.

15. Энэхүү шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор уг журмын 2.1 дэх заалтаар Зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шударгаар олгох нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болох дараах мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудсаар ил тод мэдээлэхээр зааж өгсөн.

- Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргагчид тавих шалгуур үзүүлэлт;
- Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэх үйл явц (процесс);

- Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэсэн тухай тайлан;
- Тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх мэдээлэл;
- Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын мэдээлэл;
- Сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, техникийн нөхцөл, зааглах цэгийн байршил, төлбөрийн мэдээлэл, орлого хуваарилах зарчим.

16. Стратегийн ач холбогдолтой, тэргүүлэх салбарын хувьд хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөрөнгө оруулалт, эзэмшил, төвлөрөл, өрсөлдөөнийг холбогдох хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хөгжлийн бодлогын баримт бичгээр зохицуулсан байдаг. Тухайлбал Уул уурхай, Банк санхүү, Хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт оруулах гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуулиар тусгайлан зааж зохицуулсан байна.

17. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ нь олон нийтийг соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх, олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн олон ургалч үзэл санаа бүхий хараат бус, тэнцвэртэй, бодит мэдээллээр олон нийтийг хангах үүрэгтэй байдаг бол энэхүү үүргээ хэрхэн хараат бусаар, бие даан, ёс зүйтэй хэрэгжүүлж байгааг илтгэн харуулах шалгуур нь тухайн өргөн нэвтрүүлгийн байгууллагын эзэмшил, удирдлага, бүтэц, бизнесийн болон мэргэжлийн ёс зүй, компанийн засаглалын дотоод эрх зүйн баримт бичгүүд нээлттэй ил тод байх явдал юм.

18. Энэхүү шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор журмын 2.3 дахь заалтаар хараат бус, бие даасан, мэргэжлийн Редакцын зөвлөлтэй байх, 2.4 дэх заалтаар Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааг хараат бус, бие даан, мэргэжлийн хүрээнд, ёс зүйтэй эрхэлж байгааг илтгэх дараах мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудсаар ил тод мэдээлэхээр тус тус зааж өгсөн.

- Эзэмшлийн талаарх мэдээлэл;
- Компанийн бүтэц, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, гүйцэтгэх захирал болон нэгжийн удирдлагын мэдээлэл (төрийн бус байгууллага, нөхөрлөл зэрэг өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн бүх хэлбэрт хамаарна);
- Компанийн хувьд хэрэв Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй бол түүний дарга, гишүүдийн мэдээлэл, Төрийн бус байгууллага болон бусад хуулийн этгээдийн хувьд Удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл, Нөхөрлөлийн хувьд нөхөрлөлийн гишүүдийн мэдээлэл;
- Радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийн хувьд редакцын зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн мэдээлэл;
- Гомдол ба санал, хүсэлт хүлээн авах мэдээлэл;
- Үйлчилгээний нөхцөл, хэрэглэгчийн гэрээний загвар, төлбөр тооцох арга зарчим, үнэ тариф.

19. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, түүний гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага болон холбогдох бусад эрх бүхий албан тушаалтан нь өргөн нэвтрүүлгийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж өөрийн үйл ажиллагаатай холбоотой

мэдээллийн ил тод байдлыг хангаж, өөрийн цахим хуудсаар мэдээлж байгаа мэдээллийн үнэн бодит байдлыг хариуцаж, энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахад хяналт тавьж ажиллах үүрэгтэй болно.

VI. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ ГЭЖ ЮУ ВЭ, ЯАГААД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ ЧУХАЛ ВЭ:

20. Компанийн засаглал нь компанийг үр дүнтэй удирдах, үйл ажиллагааг нь оновчтой зохион байгуулахад чиглэсэн олон талт үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний ойлголт бөгөөд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын зохистой харьцааг тогтоодог тогтолцоо юм¹.

21. Улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад үндэсний компаниудын хөгжил чухал үүрэгтэй байдаг тул хөгжингүй орнуудын санаачилга, туршлагад тулгуурлан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (ЭЗХАХБ) Компанийн засаглалын зарчмуудыг 1999 онд баталсан байдаг. "Компанийн засаглалын кодекс" буюу компанийн удирдлага, зохион байгуулалтын зарчмуудыг компанийн сайн засаглалын практикийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үздэг.

22. Компанийн тухай хууль хэрэгжиж байгаа ч компаниудын оролцогч талуудын чадамж харилцан адилгүй, компанийн дотоод эрх зүйн зохицуулалт төдийлөн хангалттай биш, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага тодорхой бус зэргээс хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, бусад оролцогч талууд хохирох, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хувьд олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн, бодит, тэнцвэртэй мэдээ мэдээлэл олж авах иргэний эрх зөрчигдөх, хариуцлагатай мэргэшсэн чөлөөт сэтгүүл зүйг хөгжүүлэх боломж алдагдаж, ардчиллын суурь зарчим хангагдахгүй байх нөхцөл бүрдэх эрсдэлийг дагуулж байна.

23. Иймээс өргөн нэвтрүүлгийн салбарт бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, бизнесийн шударга, ёс зүйтэй байдлыг хангах, компанийн сайн засаглалыг хөгжүүлэх зорилгоор компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх суурийг бий болгох шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байгааг харгалзан энэхүү журмын 2.5 дах заалтаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаандаа заавал мөрдөх дотоод эрх зүйн дараах баримт бичгийг боловсруулан баталж, өөрийн албан ёсны цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулах зохицуулалтыг тусгаж өгсөн билээ.

¹ Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолын хавсралт: Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр

- Компанийн дотоод журам;
- Байгууллагын ёс зүйн дүрэм;
- Гомдол ба санал, хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх журам;
- Хандивлагч, ивээн тэтгэгч, буцалтгүй тусламж үзүүлэгчтэй харилцах, хандив, тусламж хүлээн авах нөхцөл;
- Радио, телевизийн редакцын бодлого; хөтөлбөрийн дүрэм; сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм; төлбөртэй нэвтрүүлэг бэлтгэж, нэвтрүүлэхэд тавигдах нөхцөл, шаардлага; цахим орчинд мэдээлэл байршуулах, нийтлэх журам;
- Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн контент байршуулах, төлбөртэй телевизийг дамжуулахад тавигдах нөхцөл, шаардлага, орлого хуваарилах зарчим.

VII. БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, САНХҮҮГИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ:

24. Аливаа үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааны үр дүнг тухайн байгууллага тодорхой зорилтот түвшинд хүрч байгаа эсэхээр тодорхойлж авч үздэг бөгөөд тухайн зорилтот түвшинд хэрхэн хүрсэн, ямар арга зам ашигласан нь хараат бус байдалтай холбоотой байдаг.

25. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн зорилго, стратеги зорилт, үйл ажиллагаа нь хэвийн тогтвортой үргэлжлэхэд “хараат бус байдал” чухал нөлөөтэй бөгөөд иймээс компанийн зорилго, зорилтод хүрэх арга механизм, үйл ажиллагаа нь өөрөө хараат бус байх шаардлагыг хангах ёстой.

26. Хараат бус байдал нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны зорилго, зорилттой холбоотой байдаг тул олон нийтийн нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаандаа заавал мөрдөх зорилтот зарчмуудыг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар тусгайлан зааж зохицуулсан байдаг. Харин бизнесийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах явдал нь удирдлагын болон санхүүгийн хараат бус байдлыг хангахтай шууд холбоотой байдаг.

27. Аливаа хуулийн этгээд нь санхүү, эдийн засгийн үйл ажиллагаагаа тодорхой төлөвлөгөөнд үндэслэн гүйцэтгэдэг байх, хяналтыг уг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн байдлаар дүгнэж, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд үнэлэлт өгдөг байх шаардлагатай. Иймээс санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь учирч болох эрсдэлээс урьдчилсан сэргийлж, санхүүгийн хараат бус, тогтвортой байдлыг хангах боломжийг бүрдүүлдэг.

28. Бизнесийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хуулийн этгээд нь санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийн шинжилгээг тогтмол хийж, үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх замаар урьдчилан сэргийлж ажиллах шаардлагатай бөгөөд санхүүгийн хараат бус, тогтвортой байдал, бизнесийн тасралтгүй байдлыг хангаж ажиллах төлөвлөгөө боловсруулж баталсан байна.

29. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь бизнесийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангаж ажиллахаас гадна өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн хувьд үйл ажиллагааны хараат бус, ёс зүйтэй байдлыг хангах үүргийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-ийн дагуу хүлээж байгаа тул мэргэжлийн үйл ажиллагааны болон санхүүгийн хараат бус байдлыг хэрхэн хангах талаар энэхүү журмаар тодорхой болгохыг зорьсон.

30. Хараат бус байдлыг хангахтай салшгүй холбоотой ойлголт бол нээлттэй, тунгалаг ажиллах зарчим бөгөөд ил тод, тунгалаг байдал нь өөрөө засаглалын нэг элемент болдог. Ил тод, тунгалаг байдал болон хараат бус байдал нь харилцан биеэ нөхөх үзүүлэлтүүд юм. Нээлттэй, ил тод ажиллах зарчмын хүрээнд хараат бус байдлаа илтгэн харуулах боломжтой бол хараат бус байдлаа сайжруулснаар засаглалын чадавх нэмэгдэж, хариуцлагатай, мэргэшсэн үйл ажиллагаа бэхжиж, олон нийтэд нээлттэй компани болох суурь тавигдах боломж бүрдэнэ.

31. Тиймээс тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хэрэгжүүлсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө, шашны болон төрийн бус байгууллагын хөрөнгө, зээл, тусламж, хандиваар гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээ, мэдээлэл сурталчилгааны санхүүжилтийн талаарх мэдээлэл, мөн зохиогчийн эрхтэй бүтээл нэвтрүүлгийн жагсаалтыг өөрийн цахим хуудсаар нээлттэй мэдээлснээр үйл ажиллагааны хараат бус, ёс зүйтэй байдлыг толилуулж байгаа бол нөгөө талаасаа олон нийтийн итгэх итгэлийг нэмэгдүүлж байгаа явдал юм. Эдгээр эерэг хандлага нь хэвлэл мэдээллийн салбарт тавих олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, чөлөөт хэвлэл мэдээллийн хөгжлийг төлөвшүүлж, иргэний нийгмийг бэхжүүлэх, зах зээлд шударгаар өрсөлдөх таатай орчныг бүрдүүлэх урьдач нөхцөл болж байгаагаараа ач холбогдолтой билээ.

32. Журмын 2.8-д заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдтэй холбоотой. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд гэдэгт Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээдийг ойлгох бөгөөд энэ хуулийн 89.5 дахь хэсэгт заасны дагуу компани нь тухайн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн тайландаа тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй.

VIII. МЭДЭЭЛЛИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ:

33. Хуулийн этгээдийн эзэмшил, удирдлага болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонирхсон бусад талуудад үнэн зөв бөгөөд тогтмол хүргэх нь компанийн засаглал, хяналтын тогтолцоо сайжирч байгааг илтгэх чухал үзүүлэлт байдаг. Компанийн засаглал хяналтын тогтолцоог бэхжүүлснээр компани болон хувьцаа эзэмшигчдийн хоорондын итгэлцэл нэмэгдэнэ. Засаглалын мэдээллийг нээлттэй ил тод мэдээлэх нь тухайн компанийг хараат бус, хариуцлагатай, ёс зүйтэй гэдгийг илэрхийлэх нэг нотолгоо болж байдаг. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх бизнесийн хувьд компанийн засаглал нээлттэй, ил тод байснаар тухайн бизнесийн үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Нөгөө талдаа тухайн үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаа хариуцлагатай, ёс зүйтэй болох, олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн

тэнцвэртэй, бодит мэдээлэл түгээх үүргээ зохистойгоор хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж улмаар хөрөнгө оруулалтын үр өгөөж нэмэгдэх, бизнесийн үйл ажиллагаа тогтворжих үндэс бүрэлдэх боломжтой болно.

34. Хуулийн этгээд нь цаашдаа хууль тогтоомжид заасан, бусад чухал ач холбогдол бүхий мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг зохицуулах мэдээллийн үйл ажиллагааны дотоод журмыг батлан мөрдүүлдэг байх нь зүйтэй бөгөөд аливаа мэдээллийг нээлттэй, ил тод болгох үйл ажиллагаанд дараах нийтлэг зарчмыг хангаж үйл ажиллагаандаа мөрдвөл зохино:

- Тогтмол байх;
- Цаг хугацаандаа байх;
- Тэгш хүртээмжтэй байх;
- Үнэн зөв байх, тодорхой, ойлгомжтой;
- Агуулгын хувьд хоёрдмол санаагүй, бүрэн дүүрэн байх;
- Компанийн бизнесийн эрх ашиг, нээлттэй байх зарчмын зохистой тэнцвэрийг хангасан байх;
- Өөрийн үйл ажиллагааны доголдол, дутагдлыг нууж хаахгүй байх.

IX. ХЭТ ТӨВЛӨРЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ШУДАРГА ӨРСӨЛДӨХ НӨХЦӨЛ БҮРДҮҮЛЭХ:

35. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ нь мэдээлэл хүлээн авах хамгийн хялбар бөгөөд хүн амын дийлэнх хэсэгт хүртээмжтэй байдаг өргөн хэрэглээний хэрэгсэл болохын хувьд олон ургалч үзэл санаа, нийгмийн оролцоог хангах, иргэний нийгмийг бэхжүүлэхэд зайлшгүй оролцоотой байдаг гэж НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас (БШУСБ) боловсруулсан өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын тухай зөвлөмжид онцлон тэмдэглэсэн байна.

36. Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтад “зах зээлийн төвлөрөл гэж зах зээлд аж ахуй эрхлэгчийн дангаараа буюу бусад этгээдтэй хамтран, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдийн борлуулж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний эзлэх хувийг хэлнэ” гэж тодорхойлсон байгаагаас дүгнэхэд төвлөрөл гэдэг нь хуулийн этгээдийн дангаараа, бусад этгээдтэй хамтран, эсвэл харилцан хамаарал, нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран тухайн зах зээлд эзэлж буй хувь байхаар заажээ. Харин тухайн байх ёстой хэм хэмжээ, тогтоосон шалгуураас давсан үзүүлэлтийг хэт төвлөрөл гэж ойлгох бөгөөд энэ нь уг бараа, бүтээгдэхүүн үйлчилгээний хүрээ, газар зүйн хил хязгаараар тодорхойлогдсон зах зээлд давамгайл болон монопол байдал үүсгэх, өрсөлдөөнийг хязгаарлах эрсдэлийг дагуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

37. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний салбарын хувьд төвлөрөл гэдэг үзүүлэлт нь хүний эрх, эрх чөлөө, бодитой, тэнцвэртэй, олон талт мэдээлэл авах эрх, олон нийтийн нийтлэг эрх ашиг, хараат бус байдал, үндэсний эв нэгдлийг хангах гэдэг утгаараа үндэсний аюулгүй байдлын хэмжээнд авч үзэх чухал асуудал байдаг. Тиймдээ ч өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ тэр дундаа радио, телевизийн тусгай зөвшөөрөлтэй этгээдийн эзэмшилд ямар этгээд байх, эзэмшлийн хувь хэмжээ, хувьцаа харилцан эзэмших нөхцөл болон сүлжээ үйлчилгээг тусгаарлах хязгаарлалт, хэт төвлөрлийн шалгуур шаардлагыг хуулиар зохицуулж өгсөн байдаг.

38. Олон улсад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээд, эцсийн өмчлөгчийн эзэмшил, харьяалал, нэг болон нэгдмэл сонирхолтой этгээдэд ногдох хувьцаа, тусгай зөвшөөрлийн тоо, зах зээлд эзлэх хувь хэмжээг Өргөн нэвтрүүлгийн тухай хууль тогтоомжоор нарийвчлан тодорхойлж, өрсөлдөөн, хэт төвлөрлийг зохицуулж ирсэн.

39. Харилцаа холбооны зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн зорилт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн зорилт, 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.1.3 дах хэсэгт заасны дагуу өөрийн бүрэн эрхийн хүрээнд харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн зах зээлийн үр өгөөжтэй, шударга өрсөлдөөнийг дэмжих, өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр зорьж байна.

40. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, түүний хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд нь өрсөлдөөнийг хязгаарласан аливаа үйлдлээс урьдчилан сэргийлж, хяналт тавих бөгөөд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд аливаа хэлбэрийн монопол, хэт төвлөрөл үүсгэхээс урьдчилан сэргийлж, дотооддоо хяналт тавьж ажиллахаар журамд заасан.

41. Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19.2, 19.3 дах хэсэгт заасан мэдээлэлд үндэслэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээл, эзэмшилд хэт төвлөрөл үүссэн эсэх нөхцөл байдлыг тодруулж үнэлгээ хийх бөгөөд ингэхдээ компанийн нэгдэл, нэгдмэл сонирхолтой этгээд, харилцан хамааралтай этгээд, хувьцаа эзэмшигчээс эцсийн өмчлөгчийг харуулсан хэлхээ холбоо, тусгай зөвшөөрлийн тоо, үйлчилгээний төрөл, хөтөлбөрийн төрөлжсөн чиглэл, үзэлтийн судалгааг харгалзан үзнэ.

42. Дэлхийн улс орнуудад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төвлөрлийг тодорхойлж, зохицуулахдаа эзэмшлийн мэдээллийг үндэс болгож, төвлөрлийг үнэн, бодитой гаргахын тулд эзэмшлийг эцсийн эзэмшигч хүртэл задалж, мэдээллийг ил тод болгохыг зайлшгүй гэж үзсэн байна. Эцсийн эзэмшигчийн мэдээлэл тодорхой бус, олон нийтэд ил тод бус байх нь тодорхой хэсэг бүлэг этгээдийн гарт тусгай зөвшөөрөл төвлөрөх, давамгайл байдал бий болох, шударга өрсөлдөх нөхцөл бүрдэхгүй байх, хараат болох, үндэсний эрх ашиг хөндөгдөх зэрэг эрсдэлийг бий болгох боломжтой юм. Иймээс тусгай зөвшөөрөл олгодог байгууллагын зүгээс тусгай зөвшөөрөл олгох, эсвэл сунгалт хийхдээ төвлөрлийн үнэлгээг тухай бүр хийх зохицуулалт хэрэгждэг бөгөөд үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээд нэгдэх, нийлэх зэргээр өөрчлөн байгуулагдах тохиолдолд бүрд мэдэгдэж, үнэлгээ хийлгэх урьдчилсан нөхцөлийг журамд тусгасан.

43. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19.3 дах хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн гаргасан хувьцааных нь тав (5) ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх тохиолдолд өөрчлөлт оруулахаас өмнө энэ талаар Зохицуулах хороонд мэдэгдэж, үнэлгээ хийлгэх үүргийг журмын 3.6, 3.11 дэх заалтад тусгаж зохицуулсан. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь үнэлгээ хийлгэх хүсэлт гаргахдаа өргөн нэвтрүүлгийн

үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн хувьцаа шилжүүлэгч ба хүлээн авагчийн мэдээлэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэлийн хамт Зохицуулах хороонд ирүүлнэ.

44. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь Зохицуулах хорооноос гаргасан үнэлгээнд үндэслэн компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах эсэх тухай шийдвэр гаргаж, холбогдох өөрчлөлтийг тухайн өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай шийдвэрийн хувийг Зохицуулах хороонд хүргүүлж, өөрийн албан ёсны цахим хуудаст байршуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

45. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн харилцан хамааралтай этгээд гэдэгт Татварын албанаас гаргасан харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн ажил, үйлчилгээ, бараа, гүйлгээний тайлан болон үнэ шилжилтийн тайланд тодорхойлсон этгээдийг ойлгох бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэгдмэл сонирхолтой этгээд гэдэгт Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэгт заасан этгээдийг ойлгоно.

46. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь Компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэгт заасны дагуу өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, энэ журмын 3.6, 3.11 дэх хэсэгт заасан үнэлгээ хийлгэх хүсэлтийн хамт Зохицуулах хороонд ирүүлнэ.

47. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.1 дэх хэсэгт заасны дагуу тухайн албан тушаалд томилогдсоноос хойш арав (10) хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргах бөгөөд өөрчлөлт орсон тухай бүрд нь арав (10) хоногийн дотор компанид мэдэгдэх үүрэгтэй.

48. Хуулийн этгээдийг Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дах хэсэгт заасны дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах, 62.1.3 дах хэсэгт заасны дагуу компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох шийдвэр гаргахын өмнө энэ талаар Зохицуулах хороонд мэдэгдэж, үнэлгээ хийлгэх үүрэгтэй.

49. Зохицуулах хороо нь жилийн эцсийн статистик тайлан мэдээ, холбогдох судалгаанд үндэслэн Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дах хэсэгт заасны дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж, жил бүр үнэлэлт, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлж, энэ талаар олон нийтэд мэдээлнэ.

50. Зохицуулах хороо нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж, жил бүр үнэлэлт, дүгнэлт гаргахдаа шаардлагатай гэж үзсэн холбогдох судалгаа, мэдээллийг дараах байгууллагаас гаргуулан авч болох бөгөөд мөн уг судалгааг хараат бус хөндлөнгийн хуулийн этгээдээр хийлгэж болно:

- Татварын алба;
- Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
- Өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;
- Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн харилцагч санхүүгийн байгууллага;
- Монголын телевизүүдийн холбоо нийтийн эрх зүйн хуулийн этгээд;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд;
- Шаардлагатай бусад байгууллага.

51. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, түүний гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага болон холбогдох бусад эрх бүхий албан тушаалтан нь энэхүү журмын 2.4, 2.5, 2.8-д заасан мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцах бөгөөд журмын хэрэгжилтийг дотооддоо хангуулж, хяналт тавьж ажиллана.

52. Энэхүү журамтай холбогдон гарсан маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх бөгөөд журам зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----- о О о -----